

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-23

<i>1.Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	3-23
<i>2.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах 2 төслийг хамтатгаж хэлэлцэх эсэх тухай</i>	23

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны
04 дүгээр сарын 19-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 57 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Бямбацогт, Т.Доржханд, Б.Пүрэвдорж, Ц.Мөнхцэцэг.
Чөлөөтэй: Л.Оюун-Эрдэнэ.

Нэг.Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2023.04.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, мөн газрын Хуулийн бодлогын газрын дарга О.Машбат, мөн газрын ахлах референт Г.Сувдаа, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх А.Бямбажаргал, Монгол Улсын Их Сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал О.Мөнхсайхан, мөн сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Д.Бумдарь, судлаач Д.Энхцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Д.Тогтохсүрэн, А.Адьяасүрэн, С.Амарсайхан, Г.Ганболд, Ж.Батсуурь, Ц.Мөнх-Оргил нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Я.Содбаатар, Монгол Улсын Их Сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал О.Мөнхсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар үг хэлэв.

Н.Энхболд: Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 1
Бүгд: 11
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах 2 төслийг хамтатгаж хэлэлцэх эсэх тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд нарын 4 гишүүнээс 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 2 гишүүнээс 2023.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиудыг хамт хэлэлцэхийг дэмжиж байгаагаа хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, О.Цогтгэрэл нар илэрхийлэв.

Уг саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Уг асуудлыг 15 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 13 минут үргэлжилж, 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.9 хувийн ирцтэйгээр 15 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр,
Лхагва гараг

Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим 13 цаг 57 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: **Н.Энхболд:** Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн байна. Төрийн байгуулалтын байнгын хорооны 2023 оны 4 сарын 19-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудлыг танилцуулъя.
Өнөөдөр 2 асуудал байгаа.

Нэгдүгээрт Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгч 2023 оны 4 сарын 14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэхийг нь ярина.

Бусад асуудлын хүрээнд Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс 23 оны 4 сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах 2 төслийг хамтатгаж хэлэлцэх эсэх тухай асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотой саналтай хүн байна уу? Алга байна.

Энэ Цогтгэрэл дарга хаачив? Орж ирвэл уг нь эхний ээлжид хэлэлцэж өгөөд гялс ганцхан хэлээд л өнгөрчих юм байгаа юм. Дундуур нь явчхаж болох уу? Бас ажлын дундуур гарч ирээд саналаа хэлчихье гэсэн юм. Тэгэхээр ирэх үед нь хэлэлцэх асуудлынхаа дундуур асуугаад явчихъя.

Эхлээд Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Содбаатар, Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөх Бямбажаргал, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Машбат. Машбат байна уу? Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын ахлах референт Сувдаа, Монгол улсын их сургуулийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор, Хууль зүйн доктор Мөнхсайхан. Монгол улсын боловсролын их сургуулийн багш, судлаач, доктор Гэрэлт-Од. Гэрэлт-Од алга байна. Их сургуулийн Улс төр судлалын тэнхимийн профессор Бумдарь, судлаач Энхцэцэг ийм улсууд ажлын хэсэгт ирсэн байна.

Хуулийн болон тогтоолын төслийнхөө хэлэлцэх эсэх асуудлыг эхэлье. Хууль санаачлагчийн илтгэлийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Содбаатар танилцуулна. 4 номерын микрофон өгөөрэй.

Я.Содбаатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдэд энэ өдрийн мэндийг өргөн дэвшүүлье.

Монгол Улсын Үндсэн хуульд 2019 оны 11 дүгээр сарын арваны 14-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Монгол Улсын үндсэн хуулийн 19-ийн итрих 1-д намын Үндсэн нам үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана гэж, 3-т намын дотоод зохион байгуулалт, ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нээлттэй, ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам,

санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно гэсэн нэмэлтийг 19 оны Үндсэн хуулийн нэмэлтээр оруулсан.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжуудыг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолын хавсралтын 1.4-д улс төрийн намтай холбоотой нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх зарчмыг хангах үүднээс нам улсын хэмжээний бодлого дэвшүүлэн ажиллах, баримталж буй бодлого нь улсын хэмжээний асуудлыг хамарсан байх шаардлагыг хуульчлах, намын үйл ажиллагаа дүрэм нь хуульд нийцсэн байх, намын дотоодод шийдвэр гаргах хэлэлцэх үйл явц нь ил тод, гишүүдэд нээлттэй байх, намын дотоод зохион байгуулалт ардчилсан системд нийцсэн байх гол шалгуурыг хуульчлах, намын санхүүжилтийн эх үүсвэр, түүний зарцуулалт, тайлан нь олон нийтэд ил тод байх эрх зүйн орчныг бүрдүүлэх, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тогтоох чиглэл баримтална гэж заасан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021-2027 оны бодлого үйл ажиллагааны хөтөлбөрт улс төрийн намуудын шинэчлэлийг гүнзгийрүүлж, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, санхүүжилтийг шилэн болгох, улс төрийн нам, улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулиудыг санаачилна гэж заасан бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн нэгэн гол хэлбэр болох улс төрийн намын эрх зүйн шинэтгэлд анхаарал хандуулж, парламентад суудалтай болон бусад намууд, эрдэмтэн судлаач, төрийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 1

дүгээр сарын 6-ны өдрийн 6 дугаар захирамжаар байгуулан ажилласан юм.

Уг ажлын хэсгээс хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд парламентад суудалтай намууд болон бусад намууд, эрдэмтэн судлаачид, төрийн байгууллагын төлөөллийг хангасан олон нийтийн нээлттэй хэлэлцүүлэг уулзалт зэргийг 10 гаруй удаа зохион байгуулж, Дээд шүүхэд бүртгэлтэй улс төрийн намуудаас хуулийн төсөлд өнгөрсөн оны 5 сарын 4-ний албан тоотоор санал авч, хуулийн төсөлд тодорхой саналуудыг тусгалаа.

Хуулийн төсөлд Улсын Их Хуралд суудал бүхий намуудаас болон бусад улс төрийн намуудаас саналыг ийнхүү авсан болно.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу 2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Монгол Улсын Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцэн хуулийн төсөл түүний дагалдах хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлэн холбогдох саналыг авч төсөлд тусгалаа.

Хуулийн төсөл нь 7 бүлэг, 46 зүйлтэй бөгөөд энэхүү хуулийн төсөл нь батлагдсанаар улс төрийн намын эрх зүйн орчин сайжирч, энэ хүрээнд дараах зэрэг үр дүнгүүд гарна гэж үзэж байгаа юм.

1. Улс төрийн намын хариуцлага дээшилнэ. Улс төрийн намуудыг хариуцлагажуулна гэж тооцож байна. Намын үйл ажиллагаа дотоод зохион байгуулалт ардчилсан шашинд нийцэж, түүний санхүүжилт ил тод болох, намын гишүүдийн эрх, үүрэг хариуцлага дээшлэх, санхүү болон үйл ажиллагааны тодорхой асуудлуудаар сонгуулийн төв байгуулах, тайлан гаргах замаар олон нийтийн хяналт сайжирна.

2. Улс төрийн нам бодлогын институт болон төлөвшинө гэж үзэж байна. Нам улсын хэмжээнд бодлого

дэвшүүлэн ажиллах, үйл ажиллагаа сонгуулийн мөрийн хөтөлбөр нь улсын хэмжээний хөгжлийн бодлогодоо захирагдан хөгжлийн бодлогын хүрээнд байна. Төрийн өндөр ёс зүйтэй албан хаагчийг бэлтгэх, төр ард түмний гүүр болж ажиллах, иргэдэд улс төрийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх институт болон төлөвших үндэс бүрдэнэ гэж ингэж харж байгаа.

3. Улс төрийн намын санхүүжилт ил тод, нээлттэй хяналт сайжирна гэж тооцож байна. Намын санхүүжилт нь төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэгийн механизмыг боловсронгуй болгох түүний хяналтыг олон нийтэд ил тод нээлттэй ишлэн болгох чиглэлд эрх зүйн шинэтгэл хийгдэж байна. Намын санхүүжилт дан ганц сонгуулийн үед бус өдөр тутмын үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй болж, намд өгөх иргэдаж ахуйн нэгжсийн хандив, түүнийг захиран зарцуулалцаж сонгуулийн төв байгууллагад хяналт тавих замаар намын үйл ажиллагааг хариуцлагатай болон төлөвшүүлэх үндэс бүрдэнэ гэж харж байгаа.

4. Улс төрийн намуудын гишүүдийн нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоог хангах чиглэлд нэлээн анхаарлаа. Намын бодлогын институт болон төлөвших 1 гол үндэс нь намын гишүүнчлэлийн статусыг тодорхойлох асуудал бөгөөд хуулийн төсөлд энэ чиглэлд гишүүнчлэлийг намын гишүүн, намын дэмжигч гишүүн, намын сонгуульт гишүүн гэх мэтчилэн ангилах эрх зүйн үндсийг бүрдүүлж өглөө.

Түүнчлэн гишүүдийн тэгш оролцоог хангах улс төрд төлөөлөл нь бага хангагдаж буй иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлд жендерийн тэгш байдал, залуу болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадуудын иргэдийн улс төрийн оролцоог нэмэгдүүлэх бодлогын өөрчлөлтийг баталгаажуулах чиглэлээр тодорхой заалтуудыг тусгалаа.

5. Улс төрийн намуудын дотоод ардчиллыг бэхжүүлэх, хөгжүүлэх чиглэлд чиглэгдэж байна. Иргэдийн сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхийг баталгааг хангах хүрээнд намын бүтэц, сонгууль, гишүүдийн оролцоог хуульд тусгах замаар намын дотоод ардчиллыг дэмжих эрх зүйн үндсийг бүрдүүлэхээр хуулийн төсөлд тусгалаа.

Дээрх цогц улс төрийн намын шинэтгэлийг хэрэгжүүлснээр Монгол Улсын Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалын үндэс болсон иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөө баталгаажиж намд итгэх иргэдийн итгэл дээшилж, төрийн бодлого, шийдвэр гаргах явцад ард иргэдийн шууд оролцоо нэмэгдэж, улс төрийн намуудад өрсөлдөөний ижил нөхцөл бий болгож, авлигын түвшин буурна гэж үзэж байна.

Байнгын хорооны дарга эрхэм гишүүд ээ,

Та бүхэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, энэхүү хуулийг дагалдах хууль тогтоомжийн төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Н.Энхболд: Содбаатар даргад баярлалаа. Би энэ дундуур нь 1 жижигхэн юу яагаадахъя. Дараагийн асуудал дээр энэ Цогтгэрэл дарга, бүлгийн дарга хууль санаачлагч нэг санал хэлэх ёстой юм. Хамтарч хэлэлцүүлэх асуудал дээр. Бид нар тэгээд сүүлд нь протоколдоо байдаг газар нь бичээд явчихъя. Та байр сууриа илэрхийлчихгүй юу. Их Хурал дээр уг нь бид нар ярилцаад хэлэлцэх эсэхийг ярих үед хамтраад хэлэлцүүлэе гээд тал талаасаа тохирсон тэрийгээ баталгаажуулчихвал сайн байна. Та товчхон хэлчих үү? Микрофон, карт байгаа юм уу? Цогтгэрэл гишүүнд микрофон өгөөдөх.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын гишүүн Ганбат бид 2 хамтран Сонгуулийн тухай хуулийг өргөн мэдүүлсэн. Мөн Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиар адил агуулга бүхий хуулиудыг хууль санаачлагчид нь зөвшөөрөх юм бол нэгтгэн хэлэлцэх болох дэгтэй юм байна. Тэгэхээр энэ дэгийн дагуу өмнө нь барьсан хуулийн төсөлтэй хамтатган хэлэлцэж өгөхийг хууль санаачлагчийн зүгээс зөвшөөрч бас дэмжиж байна. Баярлалаа.

Н.Энхболд: Баярлалаа танд. Энийг бид нар дараа нь протокол дээр хэлэлцэх дараалалдаа оруулаад явчихна.

Одоо хууль санаачлагчийн илтгэл хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуулт асуух гишүүд нэрээ өгье. Мөнх-оргил гишүүнээр тасаллаа. Оюунчимэг гишүүний микрофоныг өгье.

М.Оюунчимэг: Өдрийн мэнд хүргэе. Ерөнхийдөө хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгээд 2 асуулт байна.

Нэгт нь энэ улс төрийн намуудад тавих эрх үүргийг Сонгуулийн ерөнхий хороонд өгч байгаа гэсэн заалт орж ирж байна. Тэгэхээр өнөөдөр манай улсын Сонгуулийн ерөнхий хороо энэ улс төрийн намуудад тавих эрх үүрэг дээр яг л бодитоор хяналт тавих, хариуцлага тооцох юм уу? Энийг хэрэгжилтэд нь хяналт тавиад явах хүний нөөц, хууль, эрх зүйн хувьд чадамж байгаа юу, үгүй юү гэдэг дээр нэгт хариулт авахыг хүсэж байна.

Хоёрт нь бусад хөгжсөн улс орнуудын Улс төрийн намын тухай хуулийг нь харж үзэхэд яг энэ дээр энэ удаагийн Улс төрийн намын тухай хууль, Сонгуулийн тухай хууль, гишүүдийн өргөн барьсан хуулийн дотор ерөнхийдөө нөгөө төлөөллийн тэнцвэртэй байдлыг хангах тухай асуудал, жендерийн баланс барих тухай асуудлууд нэлээд ингээд амбицтай орж ирж байгаа л даа.

Тэгэхээр энийг тэр тухайн улс төрийн нам хэрвээ төлөөллийн балансыг яг энэ Улс төрийн намынхаа тухай хуульд зааснаар бариагүй тохиолдолд хүлээх хариуцлагыг маш тодорхой аж өгчихсөн байдаг. Манайд өнөөдөр хүртэл 30 хувьд нь ийм жендерийн аль 1 төлөөллийг байршуулна гээд заачихсан хэр нь энийгээ мөрддөггүй, мөрдөхгүй байлаа гээд ямар ч хариуцлага тооцдоггүй. Хяналтын хороо нь ч юм уу эсвэл ер нь хариуцлагын механизм үйлчлэхгүй байгаа л даа. Тэгэхээр одоогийн энэ Улс төрийн намын тухай хууль дээр хэрвээ ийм зөрчил гарсан тохиолдолд ямар хариуцлага хүлээх үү гэдэг дээр тодорхой заалт тусгаж байгаа юу гэсэн 2 асуулт байна. Баярлалаа.

Н.Энхболд: Хэн хариулах вэ? 4 дүгээр микрофон Содбаатар дарга.

Я.Содбаатар: Энэ удаагийн Улс төрийн намын тухай хууль дотор орж байгаа 1 томоохон зарчмын гэмээр өөрчлөлт бол улс төрийн намуудыг бид нар 90 оноос хойш Улсын Дээд шүүх дээр бүртгээд, тэгээд төрөөс ямар нэгэн эргэж харьцдаг байгууллага байхгүй, хяналт шалгалт хийгддэггүй, улс төрийн намуудаа орхичихдог. Улс төрийн намын хуулийн хэрэгжилтийг ханган хэрэгжүүлэх ийм төрийн байгууллага байхгүй явж ирсэн. Тэр утгаараа бол 90 оноос хойш улс төрийн намуудаас хурлаа хийгээгүй, хугацаандаа хурлаа хийдэггүй улс төрийн намууд дийлэнх нь байгаа. Улс төрийн намууд эхлээд 801 хүнээр байгуулагдчихдаг тэгээд дараа нь энэ бүтэц зохион байгуулалт, улс төрийн намын төлөвших институт болж явахад маш хүндрэлтэй ийм байсан.

Тийм учраас энэ хуулиар сонгуулийн төв байгууллага ер нь улс төрийн намуудыг үндсэндээ хариуцдаг, хянан шалгалт хийдэг, тайлан юуг нь авдаг. Тэгээд парламент дээр жил болгоны 4 сард улс төрийн намуудын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ард иргэдэд нээлттэй хэлэлцдэг. Ингэж

болгоё гэдэг ийм зүйл орж ирж байгаа юм.

Сонгуулийн төв байгууллага улс төрийн намуудын энэ үйл ажиллагааг хариуцаад ирэхээр сонгуулийн төв байгууллага өөрөө хараат бус байж чадах уу? Ялангуяа эрх баригчдаас. Сонгуулийн төв байгууллагын үйл ажиллагаа цаашдаа чадавч нь ямар байгаа вэ гэдэг асуудал гарч ирж байгаа.

Тийм учраас бид нар энэ хуулийг дагалдуулаад Сонгуулийн төв байгууллагын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамтад нь өргөн барьж байгаа. Үүгээр Сонгуулийн төв байгууллага 9 гишүүнтэй байна. Тэрний 5 нь орон тооны байна. 4 нь орон тооны бус байна. Энэ 5 гишүүний 9 гишүүний 5-ыг нь бол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд нэр дэвшүүлж байна. 2-ыг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр дэвшүүлж байна. 2-ыг нь Улсын Дээд шүүх нэр дэвшүүлсэн төрийн жинхэнэ албан хаагчдаар бүрдүүлнэ гэж ингэж зааж байгаа.

Тэгээд тодорхой бас энэ сонгуулийн төв байгууллагатай холбоотой ийм хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар нэлээн томоохон өөрчлөлт оруулахаар энэ дагалдах хуульд явж байгаа юм.

Хоёрдугаар асуултын хувьд бол энэ удаагийн бас хуульд бид нар энэ улс төрд төлөөлөл нь бага хангагдаж байгаа эмэгтэйчүүдийн асуудал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал бусад энэ нийгмийн давхаргуудын асуудлыг бас тодорхой улс төрийн намуудын энэ хуульдаа их тодорхой хувилж, оруулж ирсэн. Үүний 1 юу нь бол улс төрийн намуудын дотоод сонгууль, дотоод үндэсний зөвлөх хороо, бага хурал, удирдах зөвлөл, гүйцэтгэх хороо гээд энэ төв байгууллагуудын намын байгууллагуудад эмэгтэйчүүдийн буюу жендерийн 1 хүйсийн байдлыг 40 хувиар

тооцохоор ингэж босгыг оруулж ирж байгаа юм.

Ер нь бол энэ дээр хэрвээ энэ хуульд заасан хүйсийн төлөөлөлтэй холбоотой хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хэрвээ бас сонгуульд нэр дэвшүүлбэл тодорхой хэмжээний мөнгөн урамшуулал өгөхөөр ч гэсэн заалтууд байгаа. Тэгээд эд нарыг сая яг гишүүний асууж байгаа энэ заалтуудыг хэрвээ зөрчвөл яах юм бэ гэж. Жишээлбэл 8.8 дээр аж өгсөн байгаа. Энэ хуулийн 8.2.3, 17.6-д заасан шаардлагыг хангаагүй намд тухайн зөрчлийг арилгах талаар Сонгуулийн төв байгууллага сануулна. Энэхүү сануулсан өдрөөс 6 сарын дотор зөрчил арилагдахгүй бол сонгуулийн төв байгууллага зөрчлийг арилгах хүртэл төрийн санхүүжилтийг зогсоох, тодорхой арга хэмжээнүүдийг авахаар энэ хуулийн заалтууд хийж өгсөн байгаа.

Н.Энхболд: Тогтохсүрэн гишүүн асууя.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Хуулийн төслийг ерөнхийд нь дэмжиж байгаа юм. 2, 3-н тодруулах асуулт байна.

Нэгдүгээрт, Ер нь манай улс төрийн намууд ийм идэвхгүй байдал бий болчихсон л доо. Хурлаа хийдэггүй, дарга нараа сольдоггүй, зарим нь бүүр 30 жил, 40 жил ч дарга хийж байгаа. Тэгээд нөгөө төлөөллийн байгууллага, гүйцэтгэх байгууллага гэж бараг байдаггүй. Сонгууль болохоороо гараад ирдэг, бусад үед тэгээд л байхгүй болчихдог ийм л намууд бий болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ намуудын дотоод ардчиллыг сайжруулах, энэ бүтэц, зохион байгуулалтыг нь сайжруулах чиглэлээр ямар заалтууд тусгадаг вэ гэдгийг би нэгдүгээрт нь асууя гэж бодож байгаа юм.

Хоёрдугаарт нь гишүүдийн тоотой холбоотой юм байгаа юм. Бид 2019 онд батлагдсан Үндсэн хуулийн

нэмэлт, өөрчлөлтөөр 2028 оноос эхлээд сонгогчдын 1 хувь буюу 1 нам доод тал нь 20000 сонгогчтой, өнөөдрийн байдлаар 21000 гишүүнтэй байна. Тэгэхгүй бол гишүүн биш болох буюу нам биш болох нь гэсэн ийм ойлголттой байгаа.

Орж ирсэн хуулийн төсөл дээр 801 нь хэвээрээ байгаа юм. Гишүүний тоо анх үүсгэн байгуулахдаа. Тэгэхлээр энийг ер нь нэмэгдүүлж болоогүй юм болов уу? Би бол нөгөө 28 оныхоо тоонд чиглэж 10 хувь нь байдаг юм уу, 20 хувь нь байдаг юм уу, 2000-аар ч юм уу хэлэх ёстой гэж ингэж боддог байхгүй юу.

Гурав дахь асуудал нь намын анхан шатын байгууллагуудын асуудал байгаа юм. Өнөөдөр хүн амын тоо харьцангуй өндөр нэмэгдэж байна. Энэ нийслэлийн жишээлбэл энэ хороодууд эд нар чинь нөгөө намын хурал, намын анхан шатын байгууллага буюу хорооны намын байгууллага нь хуралдъя гэхээр олон гишүүнтэй бололцоо муутай болоод ирж байгаа юм.

Тэгэхээр ер нь энэ анхан шатын байгууллагуудын асуудлыг ер нь яаж тусгав гэдэг асуудал байгаа юм. Үүр, намын үүр л дээ. Тэгээд үүр нь дотроо хэсэгтэй байх уу, үгүй юү гээд энэ бүтэц зохион байгуулалтын асуудлыг хэрхэн тусгав гэдэг ийм 3 асуултыг хууль санаачлагчаас асууя гэж бодож байна. Баярлалаа.

Н.Энхболд: 4 номер Содбаатар дарга.

Я.Содбаатар: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Ер нь манайд энэ улс төрийн парламентад суудалтай болон суудалгүй Дээд шүүхэд бүртгэлтэй 36 нам үйл ажиллагаа явуулж байна. Энэ 36 нам өөрөө нийгмийн хариу хөгжлийн хурдаас хоцорч байна гэж харж байгаа. Тийм ч учраас энэ улс төрийн намтай холбоотой маш их шүүмжлэл сүүлийн үед өрнөж бас энэ нийгэмд болж бүтэж байгаа олон

асуудлууд болж бүтэхгүй байгаа олон асуудлуудыг улс төрийн намын төлөвшилтэй улс төрийн намуудтай бас холбож тайлбарладаг. Энэ чиглэлээр судалгааны дүнгүүд тайлангууд ч нэлээн гарч байгаа.

Тийм учраас бид нар энэ улс төрийн намуудыг хариуцлагажуулах чиглэл рүү ялангуяа улс төрийн намуудын өөрсдөө бодлогын институт болж төлөвшүүлэх чиглэл рүү нь энэ хуулийн төслийн гол санал, гол агуулга байгаа. Энэ утгаараа энэ удаагийн Улс төрийн намын хуульд тусгайлан нарийвчилж зааж өгч байгаа 1 зүйл бол энэ улс төрийн намуудын дотоод ардчиллыг төлөвшүүлэх, дотоод ардчиллыг бат баталгаажуулах чиглэл рүү нэлээн олон заалтууд бүлгүүд орсон.

Ялангуяа улс төрийн нам гэж институт гээд байгаа юм бол төлөөллийн төв байгууллагатай байх, гүйцэтгэх төв байгууллагатай байх, хяналтын байгууллагатай байх, энэ байгууллагууд нь тодорхой хугацаанд хурлаа хийдэг. Тухайлбал их хурлууд нь 4 жилд 1 удаа заавал болдог байх гэх мэтчилэн нарийвчилсан хатуу заалтуудыг нэлээн оруулж өгсөн. Тэгэхгүй бол өнөөдөр энэ 30 жилийн хугацаанд 1 гэр бүлийн энэ улс төрийн нам байгуулагдсан, 1 аж ахуйн нэгж дээр нэршээд нам байгуулагдсан. Энэ 30 жилийн хугацаанд байгуулагдсанаасаа хойш их хурал гэдгээ дахиж 1 ч удаа хийж үзээгүй, үүсгэн байгуулагчийн хурлаасаа хойш хурал хийж үзээгүй намууд ч байна.

Тийм учраас энэ улс төрийн намуудын энэ дотоод юунуудыг нэлээн нарийвчилж аж өгсөн. Хэрвээ энэ улс төрийн нам хуульд заасан энэ хугацаандаа хурал зөвлөгөөнөө хийхгүй, дотоод ардчиллаа хангахгүй байвал сонгуулийн төв байгууллага тухайн улс төрийн намыг идэвхгүй хэлбэр рүү шилжүүлж, цаашидаа татан буух хүртэл арга хэмжээ авах ийм хариуцлагын

тогтолцоог оруулж өгсөн гэдгийг тодотгож хэлье.

Хоёрт ер нь энэ улс төрийн намын хуулийг өргөн барих хугацаанд энэ 18 жилийн хугацаанд 3 удаагийн оролдлого хийгдсэн юм байна лээ. Парламентад энэ 3 дахь удаагийн орж ирж байгаа төсөл. Тэгээд тэр хүрээнд ер нь улс төрийн намуудад парламентад суудалтай, суудалгүй намуудын дунд байдаг 1 томоохон асуудал бол гишүүнчлэлийн асуудлыг яах вэ гэдэг асуудал их олон жил яригдаж ирсэн. Хатуу гишүүнчлэлээсээ бид нар татгалх ёстой юм байна, хэтэрхий улс төржилтийг зогсоох, багасгах ёстой юм байна гэдэг ийм хандлага иргэдийн зүгээс, судлаачдын зүгээс тавьж байсан.

Тийм учраас бид нар энэ чиглэлээр хуулийн төсөлд тодорхой зүйлүүд оруулж ирж байгаа юм. Түүн дотор байгаа 1 асуудал бол энэ Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр орсон сонгогчдын 1 хувийн дэмжлэгийг авсан нам л улс төрийн нам болж явахаар заалт байгаа. Энэ нь гэхдээ Үндсэн хуулийн дагаж мөрдөх юугаар 28 оны 1 сарын 1-нээс хэрэгжихээр байгаа юм. Тэгэхээр бид нар өнөөдөр байгаа хүчин төгөлдөр хуулийн хүрээнд энэ хуулийн төслийг боловсруулах шаардлагатай учраас Хууль тогтоомжийн хуулийн дагуугаа 801-ээр нь аваад явж байгаа.

Ер нь энэ 36, 7 ийм олон улс төрийн нам гээд ингээд нэршээд явж байгаа энийг багасгах ёстой. Энэ цөөхөн хүн амтай ард түмэн энэ олон улс төрийн намтай байх шаардлага байна уу гэдгийг ард иргэдийн уулзалт санал их ирдэг. Энэ шинэ энэ хууль, эрх зүйн улс төрийн намын эрх зүйн орчин бүрдэж бий болох юм бол Монголд маш улс төрийн намын тоо эрс цөөрнө гэж ингэж харж байгаа. Сүүлийн 3 парламентын сонгуулийн дүнг аваад үзэх юм бол 1 хувийн босгыг давсан нам 4-5 байгаа юм байна лээ. Тэгэхээр бид нар энэ 1 хувийн босго буюу сонгогчдын 1 хувийн санал, босгыг авсан улс төрийн

намуудыг л төрөөс дэмжлэг үзүүлдэг, төрөөс хамтарч ажилладаг энэ хэлбэрүүдийг энэ хуульд тусгаж өгсөн. Түрүүний Тогтохсүрэн даргын хэлж байгаа 1 хувь цаашаа хэрэгжээд ирэх үед авах арга хэмжээ юм гэж ингэж хэлж болно.

Төгсгөлд нь энэ намын анхан шатын байгууллагуудыг намын дүрмээр зохицуулахаар.../минут дуусав./

Н.Энхболд: Адьясүрэн гишүүн асууя.

А.Адьясүрэн: Ингээд энэ хуулиас үндсэн 3 асуулт асуух гэсэн юм. Энэ төслийн 19.1 дээр намууд иргэдийн бодлогын судалгааны байгууллагатай байхаар хуульчилсан байна. Ийм боломж хэр олон намд байгаа бол? Ийнхүү заавал судалгааны байгуулалттай байх тэгээд бас сангийн хэлбэртэй байж болохоор энэ хууль дээр ингээд орсон байна л даа. Миний бодлоор намууд өөрсдийнхөө боломжоор өөрсдийнхөө дотоод дүрмээрээ энэ зүйлийг нь зохицуулах эрхийг нь өгч болохгүй байгаа юм болов уу гэдэг нэг дэх асуулт байна.

Хоёрдугаарт төслийн 21 дүгээр зүйлд Сонгуулийн төв байгууллага нь намуудыг идэвхгүйд тооцох тухай шийдвэр гаргаж байхаар заасан байна л даа. Энд 1 ойлгомжгүй зүйл нь одоо Улсын Их Хурлын ээлжит сонгуульд 2 удаа дараалан нэр дэвшүүлэн оролцоогүй бол төрийн санхүүжилтийг зогсоохоор заасан байна. Тэгэхээр мэдээж сонгуульд оролцоогүй нам тэртээ тэргүй санхүүжилт олгохгүй байгаа биз дээ? Нийт сонгогчдын 2-оос доошгүй хувийн санал авсан нам санхүүжилт авна гэхчхэн байгаа шүү дээ. Энийг яагаад ийм заалтыг оруулсан юм бол?

Мөн түүнчлэн идэвхгүйд тооцогдсон намыг бүх шатын сонгуульд оролцох эрхгүй болгож байгаа нь энэ Үндсэн хуулийн маань агуулгад хэр нийцтэй байгаа юм бол?

Сүүлчийн асуулт. Намын дэргэдэх байгууллагуудын талаар ямар нэгэн тодорхой зохицуулалтууд хуулийн төсөлд орсон уу? Товч мэдээлэл бас өгөөч. Тэгээд намаасаа ялгагдахгүй шахам энэ үйл ажиллагаатай олон тооны байгууллагууд бараг нам бүрд ажилладаг энэ иргэдийг төөрөгдүүлэхэд бас хүргэдэг. Тэгээд мөн эдгээр байгууллагуудын санхүүжилтийн асуудалд ч бас анхаарах шаардлагатай гэж би бас үздэг. Тэгээд энэ 3 асуултад бас тайлбар авъя.

Н.Энхболд: 4 номер Содбаатар дарга. Нэмэх юм байвал Мөнхсайхан бэлдэж байгаарай.

Я.Содбаатар: Энэ удаагийн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг оруулж ирэхэд 19 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт дээр улс төрийн намтай холбоотой 3 заалтыг Үндсэн хуулийн хэмжээнд оруулж ирсэн. Тэр Үндсэн хуулийн 3 заалтын 1 бол улс төрийн нам улс орны хэмжээнд бодлого тодорхойлж, цаашидаа бодлогын институт болж, хөгжлийн бодлого боловсруулдаг, хөгжлийн бодлогоороо, үзэл баримтлалаараа, үнэт зүйлээрээ уралддаг улс төрийн намууд хоорондоо өрсөлддөг, мэтгэлцдэг ийм байх чиглэлийг энэ Үндсэн хуулийн агуулгаар зааж өгсөн.

Энэ утгаараа улс төрийн намууд цаашидаа бодлогын институт болж төлөвших ёстой. Энэ агуулгаар нь аваад үзэх юм бол улс төрийн намууд иргэдээ бодлого судалгааны институттай, улс төрийн намууд иргэдээ энэ бусад олон улсад байдаг жишгийн дагуу тодорхой ийм бодлогын сангуудтай байхаар зааж өгч байгаа. Энийгээ дагуулаад төрөөс өгч байгаа дэмжлэг санхүүжилтийн хэлбэрүүдийг бас энэ тухайн намын жилийг нь зарцуулж байгаад мөнгөнийх нь санхүүгийн зарцуулалтад нь хувь аж өгч байгаа юм.

Жишээ нь 15 хувийг нь энэ хөгжлийн бодлого боловсруулахад

зарцуулна шүү, хөгжлийн судалгаа шинжилгээнд зарцуулна шүү, судалгааны ажилд зарцуулна шүү, 15 хувийг нь иргэдийг соён гэгээрүүлэхэд улс төрийн боловсролыг дээшлүүлж зарцуулна шүү гээд заагаад өгчихсөн.

Дараа нь санхүүгийн тайлан авч, аудит хийхдээ тэр хувиа хэмжээнд хүргэж зарцуулсан байна уу, юунд зарцуулсан байна гэдгийг нь санхүүгийн тайлан аудит тэр хянаад явчих. Тэр агуулгаар аваад үзэх юм бол улс төрийн намууд ийм судалгааны байгууллагатай байх чиглэл, сантай байх асуудлуудыг тусгаж өгсөн юм. Зүгээр яах вэ зарим улс төрийн намуудаас ирж байгаа саналаар бол бусад хуулийн этгээдүүд энэ чиглэлийн хуулийн этгээдүүдтэй гэрээ хийх байдлаар хамтрагч байдлаар асуудлыг зохицуулж болохгүй юу гэдэг саналыг бас хэлж байсан. Тэгээд хэлэлцүүлгийн явцад энийг анхаарч үзнэ биз гэж бодож байна.

Хоёрт намыг идэвхгүй хэлбэрт шилжүүлэх, тооцох 21 дүгээр зүйл гээд бүтэн бүлэг оруулж байгаа. Энэ бүлэг дотор 3 заалтаар намыг идэвхгүй байдал руу шилжүүлж байгаа. Та бол 1 заалтыг нь сая онцолж хэлчих шиг боллоо. Нөгөө санхүүгийн тайлан өгөх, удирдах дээд байгууллагуудынхаа хурал, төлөөллийн төв байгууллагуудынхаа хурлыг хугацаанд нь хийхгүй байх эд нарт авах арга хэмжээнүүдийнх нь заалтууд давхар явж байгаа.

Ер нь намын идэвхгүй хэлбэр тооцогдсон ч гэсэн тэнд байгаа намын гишүүдийн сонгох сонгогдох эрх бол хэвээрээ хадгалагдаж байгаа гэдгийг бас тооцож ойлгоосой гэж ингэж бодож байна.

Гуравдугаарт энэ улс төрийн намуудын дэргэдэх байгууллагын асуудлыг бид нар ерөнхий томъёолоод энэ хуулийн төсөлд орсон байж байгаа. Зүгээр яах вэ улс төрийн намуудаас ирсэн саналуудаар бол зарим сан намууд энэ улс

төрийн намуудын дэргэдэх байгууллагууд татан буугдвал яасан юм, энэ ер нь ганцхан манай улсад байдаг юм уу гэх мэтчилэн ярьж байна лээ.

Тэгээд энэ судалгаа манай эрдэмтэн судлаачид улс төр судлаачдын авч үзэж байгаагаар олон улсад байдаг жишигээр бол бүх л ардчилсан гэж байгаа, коммунист гэж байгаа бүх л улс төрийн намууд иргэдээ тодорхой хэмжээний ийм байгууллагуудтай байдаг. Тэр байгууллагууд нь олон улсын хэмжээнд залуучуудын, эмэгтэйчүүдийн энэ чиглэлийн ийм нэгдсэн олон улсын холбоонууд нь ч байдаг.

Тийм учраас энэ зүүн чиглэлийн ч бай, баруун чиглэлийн улс төрийн намуудын энэ байгууллагууд нь 100 хэд, 200-гаад намын төлөөлөлтэй ингээд байдаг юм байна лээ. Тэр агуулгыг нь аваад үзвэл энэ ганцхан Монголд байдаг зүйл юм биш юм байна. Зүгээр тэр дэргэдэх байгууллагууд өөрсдөө бие даасан хуулийн этгээд байх уу эсвэл намын бүтцийн байгууллага байж явах уу гэдэг асуудал дээр хэлэлцүүлгийн явцад бас парламентын гишүүд шийдвэр гаргах байх гэж бодож байгаа.

Ер нь энэ улс төрийн нам бол энэ санхүүг ил тод нээлттэй болгох, шилэн болгох хүрээнд улс төрийн намуудын санхүү дээр Шилэн дансны хууль хэрэгжихээр энд хуульчилж зааж оруулж байгаа. Нөгөө талдаа улс төрийн нам энэ хандив төрийн дэмжлэг авч байгаа юунууд нь 1 дансаар явахаар болж байгаа. Тэр утгаараа бол.../минут дуусав./

Н.Энхболд: 1 минут нэмээд өгчихье Содбаатар даргад.

Я.Содбаатар: Тэр утгаараа сая гишүүний хэлээд байгаа тэр улс төрийн намын дэргэдэх холбоодоор дамжиж байгаа санхүүжилт ч гэдэг юм уу, ер нь улс төрийн намуудад ирж байгаа хандив санхүүжилтийн асуудал маш ил тод,

нээлттэй, шилэн ба болж байгаа гэдгийг бас тодотгож хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Н.Энхболд: Болсон уу? Амарсайхан Шадар сайд асууя.

С.Амарсайхан: Өнөөдөр манай Монгол улсад 36 улс төрийн нам үйл ажиллагаа явуулж байна бүртгэлтэй. Өөрөөр хэлбэл 3 сая 400 мянган хүн амд 100000 тутамд 1 улс төрийн нам ноогдож байна гэж хэлж болно. Тэгэхээр улс төрийн намын шинэчлэл, өөрчлөлтийг бол зайлиггүй хийх ёстой. Энэ хуулиар, энэ бодлогоор. Энэ хуулийн 1 талд нь сонгууль бий, нөгөө талд нь төр бий. Түүний дунд төр барих улс төрийн эрхийг барих улс төрийн нам ард түмний хувь гэсэн улс орны аюулгүй байдал, тусгаар тогтнол, үнэт зүйл гэсэн олон зүйлийн зангилаа болсон энэ маш чухал хууль орж ирж байгаа юм.

Тэгээд энэ хуулийн зорилго бол ерөөсөө энэ улс төрийн намын үйл ажиллагааг ил тод нээлттэй болгох, үзэл баримтлал, үнэт зүйлүүд нь өнөөдөр хэн нь яг ямар үзэл баримтлалтай юм, ямар үнэт зүйлтэй юм, ямар тооцоо судалгаатай, тэр дундаа эдийн засаг, шинжлэх ухаан, тооцоо судалгаагаараа энэ улсын хувь заяаг цааш нь авч явах юм бэ гэдгийг иргэдэд ойлгомжтой тодорхой мэдээлэх, мэдрүүлэх, сонголтлоо хийх эрхийг нь бүрэн хангах боломж нөхцөлд хомс байгаа юм.

Өөрөөр хэлбэл институтийн бус тогтолцоогоор ихэнх намууд явж байгаа. 1 хүний бүртгэлтэй. Нэг хэсэг нөхдүүдийн сэтгэлийн хөөрлөөр тавьсан тоо баримт, мөрийн хөтөлбөртэй. Эргээд хэрэгжих боломж байхгүй. Эдийн засаг, нийгмийн үр дагавар нь тодорхойгүй. Иргэдийг хэтэрхий их сэтгэл хөдлөл, амьдрал ахуй, аж амьдралаар нь саналыг нь авах маягаар ингэж хувь заяагаар нь тоглодог иймэрхүү хандлага давамгайлж явж ирсэн.

Тэгэхээр энэ хууль бол энэ буруу хандлагыг засах ёстой ийм хууль.. Ийм тогтолцооны өөрчлөлтүүдийн нэг хэсэг нь. Гэхдээ яг түрүүн хэлсэн энэ улс төрийн тогтолцооны хувьд засаг захиргаа, засаглалын хувьд, хөгжил дэвшлийн хувьд, бүүр цаашилах юм бол хоцрогдсон эдийн засгийн бодлогын ийм уламжлалт ойлголтыг халах хэмжээний ийм том өөрчлөлтийн нэг хэсэг байх ёстой.

Тийм учраас энэ хууль дээр нэлээн том ач холбогдол өгч, би хувьдаа анхаарч ажиглаж байр сууриа ил илэрхийлж байгаа нь энэ. Бид Сонгуулийн тухай хуулиа өргөн барьсан. Одоо магадгүй үүний дараа Үндсэн хуулийн асуудал яригдах байх. Энэ 3 бол төрийг барих тулганы 3 чулуу гэж хэлж болно. Улс төрийн намын төлөвшил гэдэг бол төрийн төлөвшил, төр төвшин байх, түмэн олон амгалан байх ийм хамгийн чухал сууриудын нэг.

Тэгэхээр цаашилаад тойргийн асуудлууд яригдана, нэр дэвшилтийн асуудлууд яригдана, Үндсэн хуульд тооны асуудал яригдана. Дахиад энэ хууль дотроо эргээд харвал нам байгуулахад хэчнээн хүний гарын үсэгтэй, ямар бүтэцтэй, ямар идэвх санаачилгатай хүмүүсийн нийгмийн нэг хэсгээс нам гэдэг энэ бүтээгдэхүүн, энэ байгууллага бүрдэх юм бэ гэдгийг бид бас маш сайн тооцох ёстой.

Тийм учраас түрүүн Тогтохсүрэн даргын асуусан тэр тоон дээр би бас анхаарал хандуулдаг. Хэрвээ 20 жил оршин тогтноод 20 удаа сонгуульд оролцоод 1 ч суудал авч чадахгүй аль ч түвшинд байгаад байгаа намууд яаж цааш нь оршин тогтнох вэ, байх уу, байхгүй юу нөгөө идэвхгүй гэдгээрээ ямар шалгуураар үйл ажиллагаа нь зохицуулагдах юм бэ гэдгийг хэдүүлээ бас нэг тодруулж асууя гэж бодсон юм. Би та бүхнээс. Одоо 1 ч гишүүнгүй мөртөө 1 ч суудалгүй намууд байгаад л байна шүү дээ. 1 хүний. Тэгээд сонгууль болохоор л

гарч ирээд хүн нийгмийг үймүүлдэг. Нэгдүгээрт энэ асуудал дээр хариулт авъя.

Хоёрдугаарт төрөөс санхүүжүүлэх улс төрийн намууд гэж байгаа юм. Жишээ нь 800 хүнтэй 801-ээс дээш хүнтэй гарын.../минут дуусав./

Н.Энхболд: 4 номер Содбаатар дарга.

Я.Содбаатар: Амарсайхан гишүүнтэй ер нь их санал нэгдэж байгаа. Ер нь энэ улс төрийн намуудыг бид нар хариуцлагатай, улс төрийн намуудаас гаргаж байгаа бодлого үйл ажиллагаа нь улсынхаа бодлого үйл ажиллагаатай нэгддэг. Эргээд улс төрийн намууд чинь өөрөө энэ соён гэгээрүүлэх, төрийг байгуулах үйл ажиллагаанд оролцож байгаа институт гэдэг талаас нь харж, улс төрийн намуудыг төлөвшүүлэх асуудал руу нэлээн анхаарал хандуулж. Тийм учраас энэ удаагийн хуульд энэ чиглэлийн юмнууд процессын чанартай их олон зүйлүүдийг бас хуульчилж өгсөн. Тэр гишүүнчлэлийн хувьд би түрүүн хэлсэн 28 оны 1 сарын 1-нээс Үндсэн хууль энэ заалт хэрэгжихээр байгаа юм.

Нөгөө талдаа бид нар энэ хуулийн юун дотор ингээд та бүхэн уншаад анзаараад харвал. Ер нь бид нар энэ өнгөрсөн 30 жилийг ингээд хараад үзэх юм бол улс төрийн нам анх байгуулагдах тэр процесс дээр нь нэлээн хатуухан босго тавиад, шаардлага тавиад, ер нь улс төрийн намуудын орж ирж байгаа улс төрийн нам байгууль гэсэн иргэдийн эвлэлдэн нэгдсэн улс төрийн эрхээ хэрэгжүүлсэн энэ юунууд их цөөхөн бүртгэгдэж байсан юм байна лээ. Их олон саналууд ирж байсан юм байна лээ. Зүгээр байгуулаад орхичихдог. Тэгээд тэр байгуулсны дараа тэр нам түрүүний хэлээд байгаа энэ хариуцлагагүй, хурлаа хийдэггүй, улс төрийн нам гэхэд хэцүү 1 хүний, 1 цүнхний нам шиг ингээд явчихдаг байсан.

Тийм учраас одоо бол байгууллага тэр хүмүүсийн эвлэлдэн нэгдэх, үндсэн эрх, эрх чөлөөг хангахыг нь хэвээр нь үлдээе. Байгуулчихсаны дараа үйл ажиллагаагаа явуулахад нь хариуцлагажуулах чиглэл рүү шаардлага юуг нь өндөрсгөө гэдэг ийм ер нь концепцоор ер нь явсан. Тэр агуулгаараа бол байгуулсны дараа улс төрийн намууд энэ хуулийн дагуу тайлангаа гаргаж өгдөг, аудит оруулдаг, үйл ажиллагааны тайлан, санхүүгийнхээ тайланг гаргаж өгдөг, хурлуудаа хугацаанд нь хийдэг. Энэ олон энэ хуульд заасан энэ шаардлагуудыг хангаад явахад өнөөдрийн манай 30 хэдэн намаас маш цөөхөн улс төрийн нам энэ шаардлагыг хангахуйц байгаа юм, байгаа юм.

Ер нь зүгээр хоёрт бол төрөөс санхүүжилт болон төрийн дэмжлэг энэ авч байгаа юунууд сонгогчдын дэмжлэг буюу сонгогчдын өгсөн саналтай уялдаж байгаа юм. Нэг ёсны сонгогчдын хувийн санал авсан улс төрийн намууд бол төр шүүд бус санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Тэр нь бол улирал тутамд олон нийтийн радио, телевизийн эфирээр 30 минут өөрийнхөө үзэл бодол, хөгжлийн бодлого юугаа сурталчлах нэвтрүүлэг гаргах эрх олгож байгаа. Төрийн өмчит болон төрийн өмчийн компаниудад 1 жилд 1 удаа хурал танхимыг үнэгүй ашиглах эрх олгож байгаа.

2 хувийн дэмжлэг авч байгаа улс төрийн хүчинд бид нар төсвийн дэмжлэг, санхүүгийн төрийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлж байгаа юм. Гэхдээ энэ нь 2 хувийн босго давсан гээд үзэх юм бол 12, 16, 20 оны Улсын Их Хурлын парламентын сонгуулийг аваад үзэх юм бол 4-5 нам л 1 хувь, 2 хувийн босго давж байгаа юм.

2 хувийн босго гэвэл жил болгоны сүүлийн 4 сонгуулийг аваад үзвэл 4 субъект л давсан юм байна лээ. Бусдууд нь энэ шаардлагад нийцэхгүй байгаа. Тийм учраас ямар нэгэн дэмжлэг байхгүй.

Нөгөө талдаа бид нар өмнө нь өнөөдөр ч гэсэн Монголын төсвөөс энэ улс төрийн намуудад суудлын мөнгө гэж тодорхой хэмжээний санхүүжилт олгож байгаа. Сүүлийн 4 жилүүд аваад үзэх юм бол өнөөдрийн бид нар энэ хууль дээр туссантай хэмжээний санхүүжилтийн төсвөөс хөрөнгө мөнгийг улс төрийн намуудад бас зарцуулдаг юм байна лээ. Тэр агуулгаар нь аваад үзвэл төсвийн санхүүжилтийг сонгогчдын санал авахгүй бол түрүүний таны хэлдгээр 801 хүнээр байгуулагдсан сонгогчдын санал авахгүй 1, 2 хувьдаа хүрэхгүй бол тэнд ямар ч дэмжлэг туслалцаа үзүүлэхгүй. Тэр намууд цаашидаа бас энд оршин тогтноход хүндрэлтэй болохоор энэ хуулийн заалтууд нь орчихсон байж байгаа гэдгийг бас тодотгож хэлье. Энэ идэвхгүй хэлбэрт шилжүүлэх юугаар нэмээд Мөнхсайхан доктор нэмж хэлэх үү?

Н.Энхболд: 5 номерыг нь микрофон өгье.

Я.Содбаатар: Баярлалаа. Амарсайхан гишүүний асуултад, бас түрүүн Адыасүрэн гишүүн асуусан учраас нэмэлт тайлбар хэлье. Тэгэхээр Улс төрийн намын тухай хуулийн төслийн 21 дүгээр зүйлд бол намыг идэвхгүйд тооцох гэсэн ийм шинэ хэлбэрийн санцэ орж ирж байгаа. Тэгээд энэ өөрөө яагаад орж ирж байгаа вэ гэхээр 2019 онд Монгол Улсын Үндсэн хуулийн 19.-ийн штрих 1 дүгээр зүйлд бол намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн байна.

Хоёрдугаарт санхүүжилт нь ил тод байна гэсэн ийм зарчмууд бол туссан. Яагаад вэ гэхээр энэний цаад концепц нь бол улс төрийн нам бол зөвхөн хувь хүмүүсийн нэгдсэн ийм эвлэлдэн нэгдсэн байгууллага төдий бус энэ бол өөрөө сонгуульд амжилттай ороод төрийн эрх мэдлийг авах юм бол бас Монголын төрийн бодлогыг тодорхойлох хэрэгжүүлэх. Ийм учраас улс төрийн намыг бол ардчилсан нийгмийн институц

болохынх нь хувьд өөрөө бас дотоод ардчилалтай байх, санхүүжилт нь ил тод байх, энүүгээрээ цаагуураа авлигал янз бүрийн тэр сөрөг зүйлүүдээс ангид байх энэ тал руу нь өөрчлөх энэ суурь үзэл баримтлал явж байгаа. Энэ бол улс төрийн намын тухай либерал үзэл баримтлалаас ялгаатай. Энийг европ загвар гэж хэлдэг.

Гэхдээ энэ ганцхан Европт байдаг загвар биш. Энэ бол Канадад байна, Өмнөд Солонгост байна. Одоо манай Монгол руу орж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол намыг ардчилсан зарчмаар нь санхүүжилт нь ил тод байх, тодорхой 1 явцуу сонирхлоос хамааралгүй байх тэр тал руу нь түлхсэн ийм тодорхой хэмжээний зохицуулалт орсон загвар руу бид нар 19 оны нэмэлт, өөрчлөлтөөр орсон гэсэн үг.

Үүнийгээ үр нөлөөтэй байх үүднээс Улс төрийн намын тухай хуульд бол тэр эрх барих дээд байгууллага, төлөөллийн төв байгууллага эд нар нь тогтмол хугацаанд ядаж 4 жилд ч юм уу хуралдаж байх, ядаж 1 удаа хуралдаж байх ч байдаг юм уу, дотоод ардчилалтай байх тэр зарчмууд орчхож байгаа юм. Энийгээ биелүүлэхгүй бол яах вэ гэхээр энэчээ ийм бид нар судалж үзэж байгаад Герман, Канад зэрэг улсуудад байдаг. Намынх нь статусыг нь түр түдгэлзүүлэх буюу идэвхгүйд тооцох ийм санцү байгаа юм.

Өөрөөр хэлэх юм бол удирдах дээд байгууллага төлөөллийн төв байгууллагаа 5 жилд огт хуралдуулаагүй, эсвэл 2 жил дараалан санхүүгийн тайлангаа гаргаж өгөөгүй, эсвэл одоо Улсын Их Хурлын 2 сонгуульд дараалан оролцоогүй ч гэдэг юм уу. Тэгэхээр энэ бол өөрөө энэ саяын Үндсэн хуулийнхаа зарчмуудыг хангуулах үүднээс гарч ирж байгаа Үндсэн хуульд нийцсэн ийм арга хэмжээ.

Гэхдээ намууд саяын зөрчлөө арилгаад, тайлангаа гаргаад, сонгуульд идэвхтэй оролцоод, тэр дотоод ардчиллаа хангаад хурлаа хийгээд байх юм

бол идэвхтэй хэлбэрт шилжчихнэ. Идэвхгүйд тооцох 3 маш тодорхой объектив үндэслэл заасан учраас энэ урвуулан ашиглах эрсдэл хязгаарлагдмал.

Дээрээс нь идэвхгүйд тооцсон шийдвэр нь хуулийн энэ объектив шаардлагыг хангаагүй байхад гаргалаа гэх юм бол энэ тухай шийдвэрийг захиргааны хэргийн шүүхэд гаргаж бас хуульд нийцсэн эсэхийг нь хянуулах ийм бүрэн боломжтой байгаа юм. Тэгэхээр энэ бол намыг шууд тараах ч гэдэг юм уу ийм эцсийн арга хэмжээнээс өмнө намыг бас шууд тараана гэхээс илүү тэр алдаа дутагдлаа засаж, хариуцлагатай ажиллахад нь түлхэц өгсөн ийм сайн туршилага энэ төслөөр нэвтэрч орж ирж байгаа гэсэн нэмэлт тайлбар өгье. Баярлалаа.

Н.Энхболд: Амарсайхан гишүүн тодруулъя. Амарсайхан гишүүний микрофон.

С.Амарсайхан: 27.1 дээр Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус сонгуулийн жагсаалтад бүртгэгдсэн нийт сонгогчдын 1 сарын хөлстэй цалинтай тэнцэх хэмжээнээс 05 хувийг төрөөс санхүүжүүлнэ гэсэн байгаа юм. Тэгэхээр энэ энийг яг юу гэж ойлгох вэ? Улсын Их Хурлын сонгуулиар суудал авсан намууд санхүүжилт авна, суудал Их Хуралд аваагүй нь авахгүй гэж ойлгох уу? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, хэрвээ зөвхөн Улсын Их Хуралд суудал авсан санхүүжилт авахаар бол бусад аймаг, орон нутагт эрх барьж байгаа олонх болсон намууд ямар хэмжээний санхүүжилт авах вэ? Эсвэл авахгүй гэж ойлгох уу? Нэг бол Их Хуралд санал аваагүй бол тэр намыг идэвхтэй болон идэвхгүй үйл ажиллагаа явуулж байгаа улс төрийн нам гэж тооцохгүй байх уу? Энэ заалт яг ямар.../минут дуусав./

Н.Энхболд: Содбаатар дарга 4 номерын микрофон өгье.

Я.Содбаатар: Тэгэхээр энэ хуульд их тодорхой зааж өгч байгаа. Яг таны сая хэлсэн нийт сонгогчдын 2-оос дээш хувийн санал авсан, парламентын сонгуульд авсан намд төрийн санхүүжилт олгохоор болж байгаа юм. Одоо энэ хуулиар бол Улсын Их Хурлын сонгуулиар иргэдийн санал авснаар нь төрийн санхүүжилт олгодог болгож байгаа юм. Өмнө нь болон одоо явж байгаа хуулиар яаж байгаа гэхээр улс төрийн өнөөдрийн хуулиар бол парламентад авсан суудлын тоогоор нь хөрөнгө мөнгө хуваарилж байгаа. Аймаг орон нутгууд ялгавартайгаар Иргэдийн хурлынхаа суудлын тоогоор тодорхой хэмжээний бас дэмжлэг, санхүүгийн дэмжлэг үзүүлж байгаа.

Тэгэхээр энийг нэгтгээд бид нар энэ удаагийн хуулиар улс төрийн нам бол улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна, улсын хэмжээний бодлого тодорхойлно гэсэн учраас парламентын суудал авсан тоогоор нь ингэж явж байгаа юм.

Тийм учраас парламентаас өнөөдрийн Сонгуулийн хуулиар одоо хэлэлцэж байгаа улс.../минут дуусав./

Н.Энхболд: Ганболд гишүүн асууя. Дараа нь хариулахдаа нэмээд гүйцээгээд хариулчхаарай.

Г.Ганболд: Өмнөх Улс төрийн намын тухай хууль хэрэгжээд бас олон жил болсон. Бас муугүй хууль байсан гэж боддог юм. Айхтар тийм маргаан, зөрчил гарч байгаагүй. Тэгээд энэ дээр л үндэслэж байж дараагийнхаа намын хуулийг санаачилж оруулж ирж байгаа байх гэж ингэж бодож байна.

Тэгэхээр улс төрийн нам дээр бол ерөөсөө гол асуудал бол үүсгэн байгуулах, татан буулгах, санхүүжилт тэгээд л тайлангийн асуудал байгаа юм л даа. Тэгэхээр энэ хууль батлагдсанаар одоо байгаа улс төрийн намууд дахин бүртгэлд

орох уу? 801 гишүүн бүрдүүлээд ингээд бүгдээрээ дахин бүртгэлд ороод, дахиж шинээр бүртгүүлээд явах уу? Эсвэл өнөөдрөөс хойш шинээр байгуулагдах намуудад л хамааралтай байна уу гэдэг л асуулт асуучихъя.

Үүсгэн байгуулсны дараа татан буугдах тухай асуудал байгаа юм л даа. Ингээд өмнө нь бид нар чинь ингээд л ерөнхийлөгч байсан хүн шууд гарч ирээд л улс төрийн намыг тараах зарлиг ч билүү захирамж гаргаад л ингээд л нийгэмд үймээн самуун шахуу юм үүсгээд л явж л байсан л даа. Тэгээд одоо энэ Ардчилсан намыг харахад бол одоогоороо би цэцэрлэггүй байгаа л гэж ойлгоод байгаа юм. Дарга нь 1 хүн, тамга нь 1 хүн дээр, гэрчилгээ нь 1 хүн дээр. Одоо яг ийм бэлэн кэйсийг л бид нар энэ хуулиар ямар ч хоорондоо маргаан мэтгэлцээнгүйгээр шийдэх л ийм хуулийг л бид нар батлах ёстой.

Тэгээд энэ нь жишээлэх юм бол энэ Ардчилсан намын энэ бэлэн байгаа ингээд дарга нь тамгагүй, тамгатай, гэрчилгээтэйгээ энэ 3 даргатай юм шиг энэ байгаа байдлыг энэ хуулийн яг аль заалтаар яг шууд шийдэхээр байгаа вэ гэдгийг асууя.

Дараагийнх нь энэ улс төрийн төрийн санхүүжилтийн асуудал. Энэ хуулийн би гол зорилго нь бол улс төрийн намын санхүүжилтийг ер нь шилэн ил тод байлгая, төрөөс тодорхой хэмжээний санхүүжилт олгодог болгоё гэдэг ийм зорилго агуулж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд эхний энэ 27.1-ээр бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 0.5-аар, нийт сонгогчдын нэрсийн жагсаалтад орсон хүмүүсээр үржүүлнэ гэхээр тав аравны хэдэн тэрбум төгрөг л юм байна л даа. Тэгээд энийг нь хуваагаад үзэх юм бол 1 намд хэдхэн төгрөг 36 нам байгаа бол мэдээж 2 хувийн босго давсанд нь л өгөх байх.

Тэгээд ингээд бодохоор бол их бага мөнгө байгаад байгаа юм л даа. Тэгэхээр

нөгөө нийгэм бол ингээд бодохдоо төрөөс мөнгө өгдөг болчихсон улс төрийн намууд. Тийм учраас эд нар янз бүрийн гаднаас хандив тусламж авахгүй байх ёстой гэдэг ийм хүлээлт байгаад байдаг.

Гэтэл ингээд жоохон юм чинь ингээд олон намд хуваагдаад ирэх дээр зэрэг бараг өгснөөсөө өгөөгүй нь шулуун ч юм шиг л ийм л харагдаад байна л даа.

Хоёр дахь нь бол мэдээж сонгуулийн дараагийн санхүүжилт жил болгон өгдөг. Энэ томьёогоор нь би зүгээр дотроо жоохон үржүүлж үзлээ л дээ. Өмнөх одоогийн өгч байгаа санхүүжилтээс арай илүү л юм шиг л бай харагдаж байна. Мэдэхгүй зүгээр багцаагаар бодоход шүү дээ. Энэ дараагийн санхүүжилтийн асуудал нь өмнөх өгч байсан одоо өгч байгаа шүү дээ. Парламентад суудалтай намуудад гишүүдийн тоогоор, тэрнээс ер нь ямархуу хэмжээнд байхаар тооцож гаргасан бэ? Миний бодож байгаагаар жаахан нэмэгдэх л юм шиг л харагдаж байна. Зүгээр ямар байх юм бол? Би эхний тэр санхүүжилт дээр ийм бага юмыг ингээд олон намд хуваах нь бол жаахан үр дүн муутай юм биш биз дээ л гэж би бодоод байна л даа. Нийгэм хүлээхдээ бол улс төрийн намуудад төрөөс баахан мөнгө өгдөг болчихсон гэж боддог.

Гэтэл хуваахаар энэ чинь бол тав аравны хэдэн тэрбум төгрөг л байна шүү дээ. Тэгээд 1 хуваахаар тэгээд 1 намд хэдэн зуун сая төгрөг ч юм оногдох юм? Энэ зүйлүүдийг ер нь тодорхой болгож өгөөч. Ер нь хууль дээр бид нар үүсээж магадгүй энэ маргаан дээр л сая Амарсайхан гишүүний хэлж байгаа ч гэсэн үнэн л дээ. Яг цаашидаа яг маргаан гарч магадгүй тийм яг заалтууд дээрээ л их тодорхой татан буулгахыг нь хэн нэгэн хөндлөнгийн хүн орох.../минут дуусав./

Н.Энхболд: 4 номер Содбаатар даргын микрофоныг өгчих.

Я.Содбаатар: Энэ удаагийн энэ хуулийн юун дээр яг Ганболд гишүүний хэлээд байгаа тэр саналуудыг нэлээн сайн тусгаж энэ 30 жилийн хугацаанд улс төрийн намуудад ялангуяа 2005 оны хууль гарснаас хойш 18 жил болж орж ирж байгаа хууль. Тэгээд энэ хүрээнд ямархуу проблемууд үүсээж байсан юм? Өнөөдрийн эрх барьж байгаа Ардын нам дээр ч, өнөөдөр парламентад суудалтай хүн нам дээр ч, Ардчилсан нам дээр ч, парламентад суудалгүй өнөөдөр хүртэл Дээд шүүх дээр 2, 3 намын маргаан явж л байна.

Тийм учраас энэ маргаануудыг бид нар энэ хуулийн хүрээнд санкцыг нь яаж тодорхой болгох юм гэдэг асуудлаар энэ намуудаас нь бас нэлээн санал авсан. Тэр саналууд тодорхой тусгаж өгсөн. Тухайлбал, улс намын бүртгэх бүртгэхээс татгалзах энэ зүйлүүдийг улсын сонгуулийн төв байгууллага дээр хянаад тэгээд Улсын Дээд шүүх рүү шилжүүлж байгаа. Улсын дээд шүүхүүдийн хэзээ, яаж шийдвэр гаргах вэ гэдэг нь хоног хугацаатай маш нарийн зааж өгч байгаа. Тэр гэрчилгээ юунаас эхлүүлээд юунуудыг нь бас хоног хугацаатай маш нарийн аж өгсөн. Улс нь бол урьд нь энэ чинь хуулийн этгээдийн юу гээд улсын бүртгэл дээр нэгдсэн юугаар явж байсан.

Одоо энэ удаа сонгуулийн төв байгууллага дээрээс намыг улс төрийн намын бүртгэлд бүртгэх шийдвэр нийтэд мэдээлснээс хойш ажлын 5 өдөр дотор сонгуулийн төв байгууллага гэрчилгээ олгоно гэх мэтчилэн нэлээн нарийвчилж ингээд процессын чанартай шахам болгож ингээж хуульчилж өгч байгаагаараа нэлээн онцлог. Хууль хэрэгжих хүрээнд энэ зүйлүүд нэлээн явах байх гэж ингээж бодож байна.

Хоёр дахь асуултад бол Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрвээ батлагдвал Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж мөрдөх журмын тухай хууль гэдэг төслийг бас дагах хуулийн

төсөлд хамт өргөн барьсан байгаа. Тэр дотор энэ Улс төрийн намын энэ шинэ хууль гарсантай холбогдуулан өмнөх хуулиараа хүчин төгөлдөр явж байгаа энэ улс төрийн намуудыг дахин бүртгэхгүй.

Харин нам, тухайн улс төрийн хүчнүүд өөрийн дүрэм, хөтөлбөр, дотоод зохион байгуулалтыг улс төрийн намын энэ шинэ хуультай нийцүүлэн эрх зүйн орчинтой нийцүүлэн сонгуулийн төв байгууллагад өгөх хугацаа юунуудыг нь зааж өгч байгаа өөрчлөлтүүдээ. Нэг ёсны улс төрийн намууд энэ шинэ хууль гарсантай холбогдуулж энэ хуулийн дагуу хууль, өөрийнхөө дотоод журам, юмнуудаа өөрчлөөд янзлаад, хуульд нийцүүлээд ингээд явах ийм юуг нь дагаж мөрдөх журмын тухай хуулиар зохицуулж өгсөн.

Гурав, ер нь бол энэ улс төрийн намуудад өнөөдөр яаж явж байгаа вэ? Одоо энэ хуулиар ямар ялгаатай вэ гэдэг 2 зүйл байгаа. Одоо бол би түрүүн хэлсэн. Өнөөдөр сонгуулийн дараа авсан суудлынх нь тоог парламент дээр, орон нутагт авсан юунууд дээр нь тодорхой хэмжээний суудлын мөнгө дэмжлэг үзүүлдэг.

20 он, 21 он, 23 оны өнөөдрийн байдлаар улсын төсвөөс энэ улс төрийн намуудад үзүүлсэн дэмжлэгийг ингээд аваад үзэх юм бол 4 жилээр нь аваад үзэх юм бол хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 21 тэрбум төгрөг байгаа. Энэ 4 жилийн хугацаанд олгосон байгаа. Тэгэхээр энэ удаагийн өөрчлөлтөөр бол улс төрийн намуудад төрийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхдээ парламентад авсан сонгогчдынх нь саналтай уялдуулж тооцохоор болж байгаа юм.

Нэг ёсны сонгогчдын саналын дэмжлэг авахгүй сонгогчдоос дэмжлэг авахгүй бол тэр улс төрийн намд дэмжлэг үзүүлэхгүй. Тэгээд тэр нь улс төрийн 2 хувийн босго давахгүй бол тэр улс төрийн намуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхгүй.

Тийм учраас 30 хэдэн нам энэ мөнгийг авах гээд байгаа зүйл биш. Ард иргэдийн дэмжлэгийг авсан 2 хувийн босго давж байгаа. Хэлэлцүүлгийн явцад би зүгээр энэ хувийг өөрчлөгдөхийг мэдэхгүй байна. Тэр давсан тэр улс төрийн хүчнүүд л сонгогчдын авсан саналаараа тодорхой авч байгаа. Тэр нь яг өнөөдрийн энэ өргөн барьсан төслөөр бол энэ хэмжээний 21 тэрбумаас хэтрэхгүй байгаа.

Ер нь сонгогчдын дэмжлэгийг авахгүй бол энэ төрийн дэмжлэг авахгүй гэдгийг бас онцолж хэлмээр байгаа юм. Тэгэхээр сонгогчидтойгоо ажиллаж, сонгогчдын дэмжлэгийг авч хүлээн зөвшөөрөгд.../минут дуусав./

Н.Энхболд: Батсуурь гишүүн асууя.

Ж.Батсуурь: Энэ Улс төрийн намын тухай хууль бол төрийн тогтолцооны суурь хууль болж харагдаад байна л даа. Ер нь ч Монгол Улсын бүх нутаг дэвсгэр дээрх төрийн үйл ажиллагааны энэ зарчмыг бас тогтоож өгөх л ийм хууль болж харагдаад байгаа юм.

Тэгэхлээр энэ парламентад суудалтай нам, аймгийн иргэдэд төлөөлөгчдийн хуралд суудалтай намууд нь шат шатад ажиллах боловсон хүчний тогтолцоог ер нь энэ хуульд яаж тодруулж гаргаж ирж байна уу? Зэрэг дэвийн асуудал, орон тооны хязгаарын асуудлуудыг ер нь зааж байгаа зүйлүүд байна уу?

Одоогийн байдлаар энэ парламентад суудалтай намын ажиллаж байгаа улс төрийн намд ажиллаж байгаа хүмүүсийг төрийн албанд ажилласан жилээр тооцож байгаа заалт байгаа. Энэ цаашдаа хэрэгжих үү?

Дээр нь цалингийн сүлжээ орон тооны хязгаарыг энэ дээр зааж өгөх үү баримжаагаар?

Дээр нь Улсын Их Хурал аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, сумын Иргэдийн хурал, багийн Засаг дарга бол энэ улс төрийн намын хуультай шууд холбоотой байдаг л даа. Тэгэхлээр энэний санхүүжилтийг үндсэнд нь бүрэн зогсоосон гэж харж болох уу гэж.

Дээр нь хөрөнгийн асуудал. Хөрөнгийн хязгаар байна уу? Ямар нэгэн байдлаар? Жишээлэх юм бол нэг гараанаас гараагүй учраас зарим газрууд маш том байртай байдаг, зарим нь байргүй байдаг. Байр түрээсэлсэн орлого энэ намын үйл ажиллагаанд зарцуулагдах уу? Мөн энэ хандив мөнгө гэж үзэх үү? Мөн намын гишүүдийн татварыг хязгаар тогтоож өгөх үү?

Жишээлэх юм бол удирдах дээд байгууллага, Ардын намаар бол Бага хурал Ардчилсан намаар бол Үндэсний бодлогын хороо, бусад намуудын ямар ч байдаг юм эдгээрийн татварыг хязгаар байх уу? Жишээлэх юм бол намын санхүүжилтээ босгохын тулд намын удирдах дээд байгууллагын татвар намаа авч явахын тулд хэт өндөрсөх тэр өндрийг хязгаарлаж өгөхгүй бол гишүүд, дэмжигчдээсээ тасрах, мөн тэнд авлигал, хээл хахууль нуугдах энэ тэр гэсэн ийм асуудлууд гарах эсэхийг судалсан зүйл байдаг юм болов уу гэсэн энэ хэдэн асуултуудыг боловсон хүчин, хөрөнгө, татвар, мөнгөтэй холбоотой асуудлуудыг тодруулсны дараа ахиж нэмж асууя гэж ингэж бодож байна.

Н.Энхболд: 4 номер.

Я.Содбаатар: Өнөөдрийн мөрдөгдөж байгаа Төрийн албаны тухай хуульд байгаа тэр заалтыг хөндөөгүй. Намын ажилтны цалин намын юунуудынх нь юуг бас намын дотоод дүрмээр өөрийн юугаар зохицуулахаар заасан. Ялангуяа парламентад суудалгүй намуудаас ирсэн санал дотор энэ намын анхан шатын байгууллага, дунд шатын байгууллагууд ямар байх вэ гэдэг асуудлыг нэлээн

маргаантай байсан төслийн хэлэлцүүлгийг явцад.

Тийм учраас бид нар энэ улс төрийн намуудын дотоод асуудлуудыг ялангуяа намын ажилтантай хэдэн төгрөгийн цалин өгөх үү яах вэ гэдэг асуудлыг намын дотоод асуудал гэж орхисон.

Намын хөрөнгийн хязгаарын асуудал яригдаж байгаа. Тэгэхээр өнөөдөр улс төрийн намууд яг улс төрийн намууд дээр бүртгэлтэй хөрөнгө их бага болчихсон юм байна лээ. Зарим нь намын гишүүдийн хөрөнгө болоод нийтийн хөрөнгө болгоод өөрчилчихсөн. Зарим нь төрийн бус байгууллага дээр шилжүүлээд хуулийн этгээдэд шилжүүлчихсэн тэгээд түрээсийн гэрээтэй байдаг. Гэхдээ бид ард түмэн харахдаа энэ бол Ардчилсан намын байр, энэ Ардын намын байр, энэ тэр намын байр гэж боддог.

Гэхдээ бодит байдал дээр яг эрх зүйн талаасаа нэлээн маргаантай байх ийм нөхцөлүүд бас байгаа юм байна лээ. Судалгааны хэлэлцүүлэг нөгөө хууль боловсруулж байх явцад харахад.

Тийм учраас бид нар энэ өөрийн хөрөнгөөс орж ирж байгаа орлогын юуг хязгаарлаж тавьсан. Таны түрүүний хэлдэг төрийн санхүүжилтийн 50 хувиас хэтрэхгүй гэдгийг бол хязгаарлаж өгсөн байж байгаа. Энэ 35.4-өөр.

Нөгөө талдаа гишүүдийн татварын дээд хязгааруудыг бас тогтоож өгсөн 1 жилд өгөх. Ер нь энэ хуулийг боловсруулж байх явцад энэ харин хандив мөнгөтэй холбоотой, гишүүдээсээ хандив нэрээр авдаг янз бүрийн татвар нэрээр авдаг зүйлүүдтэй холбоотой, дэнчин нэрээр авдаг асуудлуудыг маш их шүүмжилж хэлэлцүүлгийн явцад гарч ирсэн.

Тийм учраас бид нар аль нэгэн улс төрийн нам сонгуульд хүн дэвшүүлэхийнхээ төлөө дэнчин авдаг,

мөнгө төгрөг авдаг юмнуудыг хуулиар хориглож байгаа. Сонгуульт гишүүний сарын татварын хэмжээг 1 сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй гэсэн ийм хязгаарлалт тухайлбал хийж байгаа. Гишүүний татварын хэмжээг ч гэсэн хязгаарлалт жоохон хийж байгаа.

Нэг ёсны улс төрийг мөнгөний хамаарлаас хандив, мөнгө гэдэг нэрээр орж ирж байгаа энэ хөрөнгө мөнгөний хамаарлаас багасгах, холдуулах. Ер нь улс төрд энэ өндөр хэмжээний мөнгө орж ирдэг, мөнгөтэй хүн энэ улс төр хийдэг гэсэн энэ ойлголт энийг багасгах чадалтай, мэдлэг боловсролтой, ёс зүйтэй иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэгш оролцоог хангах энэ хүрээнд хуулийн төслийн ерөнхий агуулга явж байгаа учраас энэ заалтын хязгаарлалтууд нэлээн хийгдсэн.

Зарим улс төрийн намууд бас энэ хэмжээний хөрөнгөөр энэ намууд цаашидаа ажиллаж чадах юм уу ч гэж асууж байна лээ. Тэгэхээр ийм хэмжээнд бид нар бас энэ улс төрийн намууд тэр соён гэгээрүүлэх, хөгжлийн бодлогоо тодорхойлох, гишүүдээ боловсруулах, ёс зүйтэй байх, тэр гишүүдээ тавьдаг шаардлага байх энэ чиглэл рүү нь илүү анхаарал хандуулсан ийм үйл ажиллагаагаа ч явуулах чиглэлийг санхүүгийнх нь хязгаарлалтуудаар бас хийж өгсөн гэж ингэж ойлгож байгаа гэдгийг бас тодотгож хэлье.

Н.Энхболд: Батсуурь гишүүн нэмж асууя. Сая намын гишүүдийн татварын хязгаарыг л ярьчих шиг боллоо. Удирдах дээд байгууллага гэдэг нь намын гишүүд л гэж ойлгох уу? Би онцолж асуусан юм шүү дээ. Жишээлэх юм бол парламентад суудалтай намыг би Бага хурлын гишүүд Үндэсний бодлогын хорооны гишүүд гэх мэт эдгээрт хязгаар байна уу, байхгүй юу гэсэн зүйл байж байна.

Дээр нь төрийн албаны хуульд тэр юу үлдэж байгаа гэж байгаа юм. Тийм заалт хэрэгжээд байдаг боловч тэр чинь өөрөө түрүүний төрийн албаны хуулиараа цалингийн сүлжээ, шатлал гээд л явах ёстой л доо. Тэгэнгүүт төрд ажилласан он жилүүдэд нь тооцоод байдаг. Тэгсэн мөртөө тэтгэвэр тэтгэмжид гарахад гэдэг юм уу, ажилласан жилээ тооцуулахад гээд ингээд эдгээр зүйлтэйгээ зөрчилдөөд байдаг.

Тэгээд энийг энэ намын дүрэм журмаар энэ улс төрийн намын тухай хуулиар нэгмөсөн нэг тийш нь болгож өгвөл яасан юм бэ?

Н.Энхболд: Содбаатар 4 номер.

Я.Содбаатар: Энэ улс төрийн намын хуулийн төсөлд бол сонгуульт гишүүн гэдэг ойлголт гарч ирж байгаа юм. Сонгуульт гишүүн гээд яг одоо Батсуурь гишүүний хэлээд байгаа. Үндэсний зөвлөлдөх хорооны гишүүн гэдэг юм уу, намын бага хурлын гишүүн гэж юм уу, удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх хорооны гишүүн гэдэг шиг тэгээд сонгуульт гишүүний сарын татварын дээд хязгаарыг тогтоогоод өгчихсөн. Тэгээд тэр хэмжээгээр сонгуульт гишүүн сарын татвар өгнө. Тэгээд намын гишүүн бусад гишүүний өмнөөс татвар төлөхийг бас хориглочихсон байж байгаа юм. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр. Одоо 420000 өнөөдрийн байгаагаар. 550000 төгрөг сарын. Ингээд хязгаарлалтаа хийгээд өгчихсөн.

Тийм учраас энэнээс хэтрэхгүй гэж ингээд заагаад өгчихсөн байж байгаа. Тийм учраас нөгөө талдаа бас намын гишүүн гээд бусад гишүүний өмнөөс татвар төлдөг, тэгээд тэр нь фракцаараа ингээд төлж байгаа гээд оруулаад ирдэг ийм зүйлүүдийг байгаа. Эд нарыг бүгдийг нь хязгаарлалтууд нэлээн хийж өгсөн байж байгаа. Зүгээр саяын

таны тэр Төрийн албаны хууль сүүлд.../минут дуусав./

Н.Энхболд: Мөнх-Оргил гишүүн асууя.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Энэ их зовлонтой асуудал л даа мэдээж. Тэгээд хамгийн гол нь энэ н улс төрийн намууд чинь яг эрх зүйн утгаар нь аваад үзэх юм бол нөгөө төрийн бус байгууллагууд байгаад байдаг. Өөрөөр хэлбэл нийтийн эрх зүйн субъект бол үндсэндээ биш л дээ. Хувийн эрх зүйн субъект.

Гэхдээ нөгөө талаас улс төрийн нам нь өөрөө энэ улс төрийн системд их чухал үүрэг гүйцэтгэдэг учраас заавал төрийн хууль тогтоомжоор нарийвчлан зохицуулах асуудал нь гараад байдаг. Тэгээд хуучин өмнөх хуулиараа бол бид нар миний бодлоор шүү. Бид нар энэ дотоод асуудлыг нь их зохицуулсан юм байна лээ. Өөрөө дотоод ардчиллынхаа зарчмаар шийдэж болох асуудлуудыг намын бараг дүрэм, журамд орчихоор юмнуудыг бид нар бүгдийг нь хуульчлаад тэгээд ингээд намуудын дотоод проблемуудыг нь шийдэхийн тулд хуульчлаад өөрсдийгөө зовоочихсон. Энэ хууль дээр тэр алдаанаасаа сураад тэрийг нь арай жосоохон орхиж өгч байгаа юм уу гэж би зүгээр ойлголоо.

Тэгээд 1 зохицуулах гол асуудал бол санхүүжилтийн асуудал л даа. Тэгээд төрөөс санхүүжүүлэх зарчмыг их ойлгомжтой болгож ирж байгаа юм байна. Тэгээд Содбаатар даргаас ийм асуултууд байгаа юм.

Нэгдүгээрт энэ улс төрийн намуудын санхүүжилтийн хууль гэж тусад нь хууль оруулж ирэх хувилбар байсан уу? Тийм бололцоо байна уу? Энэ ерөөсөө тэр рүүгээ л явна. 1 хуулиар миний бодлоор бид нар энийг 1 удаадаа ингээд зохицуулна. Энэ чинь өөрөө мөнгө төгрөгтэй холбоотой, улс төрийн намуудын цаашдын хөгжилтэй холбоотой учраас бүүр нарийвчилсан

зохицуулалтууд орж ирээд л байна. Ийм нэг асуулт байна.

Хоёрдугаарт энэ улс төрийн намууд чинь төрөөс санхүүжнэ. Мэдээж гишүүдээсээ юм уу, хувийн эх үүсвэрүүдээс хандив авна л даа. Тэгэхлээр энэ хуулийн 1 том зорилго бол намын гишүүн ч байна уу, намын гишүүн биш ч байна уу улс төрийн намд ямар нөхцөлтэйгөөр хэдэн төгрөгийн хамгийн дээд талын хандив өгч болох юм бэ гэдгийг л бид нар ойлгомжтой болгож өгмөөр байгаа юм. Аж ахуйн нэгж бол төд, энэнээс илүү өгөхгүй шүү. Төдөн намд өгнө эсвэл бүх намд өгч болно, эсвэл ганцхан намд өгч болно, ингэж өгнө, сонгуулиар ингэж өгнө, бусад үед ингэж өгнө гээд нөгөө аж ахуйн нэгжүүд, хувь иргэд их тийм эрх зүйн ойлгомжтой нөхцөлд ормоор байгаа юм. Энийг яаж зохицуулж өгч байгаа вэ?

Гурав дахь асуулт ерөөсөө улс төрийн намын санхүүжилтийн хамгийн гол асуудал бол сонгуулийн санхүүжилт. Ерөөсөө л сонгуулийн санхүүжилттэй шууд холбоотой. Сонгуулийн санхүүжилт нь сонгуулийн тогтолцоотойгоо шууд холбоотой. Тэгээд энэ улс төрийн намуудын санхүүжилтийг цэгцлэхийн тулд төрөөс дэмжлэг тусалцаа үзүүлэхээс гадна сонгуулийн зардлыг багасгадаг л байх хэрэгтэй байгаа юм. Сонгуулийн зардлыг багасгахад бид нар ерөөсөө мэдэж байгаа шүү дээ. Хоёрхон л том үндсэн зардал байгаа юм. Ухуулагч нарын зардал, хэвлэл мэдээллийн зардал. Хэвлэл мэдээллийн зардал бол тодорхой хэмжээнд гарна.

Яагаад гэвэл нөгөө мөрийн хөтөлбөр, хүнээ танилцуулах ажил гарна. Энэ ухуулагч нарын зардал дотор энэ хуулиар шууд тусгадаггүй юм гэхэд мэдээж энэ хуулийг та нар бодож байхдаа Сонгуулийн хуультайгаа уялдуулж орж ирж байсан биз. Энэ ухуулагч нарын зардлыг багасгах дээр юу оруулж ирсэн бэ? Энийг нэгт.

Дөрөв дэх асуудал ерөөсөө санхүүжилттэй холбоотой хамгийн гол асуудал бол энийг, хуулийг, тодорхой хуулийг хэрэгжүүлж байна уу, үгүй юү? Хэрэгжүүлж байгаа бол ямар урамшуулалтай юм? Хэрэгжүүлэхгүй байгаа бол ямар санкцтай юм?

Н.Энхболд: Хэн хариулах уу? 4 номер Содбаатар дарга.

Ц.Мөнх-Оргил: Би тэр санхүүжилттэй холбоотой хэсгийг нь хариулъя. Нийтийн эрх зүйн этгээд, санкцтай холбоотой хэсгийг нь Бямбажаргал зөвлөх нэмж хариулъя.

Төрийн санхүүжилт ер нь улс төрийн намын санхүүжилтийг сонгуулийн үеийн санхүүжилт, сонгуулийн бус үеийн санхүүжилт гэж авч үздэг. Анх бид нар ер нь Улс төрийн намын хууль, Улс төрийн намын санхүүжилтийн хууль гэж 2 бие даасан хууль болгоё гэж. Энэ хүрээнд ерөнхийдөө бас ярьж ийм төслийн эхний хувилбар ч гарч байсан. Тэгээд улс төрийн намуудын хэлэлцүүлгийн явцад олон улсад байдаг сайн жишээ болж байгаа улс төрийн намын эрх зүйн орчинтой гэж байгаа орнуудын туршилага эд нарыг авч үзээд ер нь нэгтгээд 1 хууль байж байх нь зүйтэй юм байна гээд. Ингээд 1 хуульд ороод ирчихсэн.

Үүгээр бас энэ яг улс төрийн намын энэ санхүүжилттэй холбоотой асуудлаар бас тусгайлан судалгаа ч хүртэл хийлгэж үзсэн. Тэгээд энэ хүрээндээ энэ нь зөв юм байна гээд ингээд нэгтгэсэн хууль болоод орж ирсэн.

Та түрүүн хэллээ. Төрийн санхүүжилтийн юуг нэлээд тодорхой болгосон юм байна гэж. Хандивыг бас нэлээд тодорхой болгож өгсөн. Улс төрийн намд жилдээ эцсийн өмчлөгчөөрөө 1 хуулийн этгээд нийт дүнгээрээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин үржүүлсэн буюу одоогийн ханшаар бодох юм бол 27 сая

төгрөг л өгөх ийм боломж энүүгээр нээгдэж байгаа юм.

Хувь иргэн жилдээ 1 жилийн дүнгээрээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 12 дахин үржүүлсэн буюу ойролцоогоор 6 сая гаран төгрөг хандивлах боломж нээгдэж байгаа юм. Энэнээс илүү хандив өгөх нь хуулиар хориотой. Тэгээд тэрийг улсын орлого болгох гээд тодорхой хатуу заалтууд орчихсон. Өмнө нь бол хандивын юуг бол, сонгуулийн үеийн хандивыг бид нар 10 саяар хуулийн этгээдийн хувийг бол 5 саяар гээд ингээд явдаг байсан. Энийгээ хэдэн удаа бас олгож болдог байсан. Хуулийн этгээдүүд өнөөдрийн хуулиар хуулийн этгээдүүд охин компаниараа, хамаарал бүхий компаниудаар олгож болохоор байгаа.

Энэ бол эцсийн өмчлөгчөөр 27 сая төгрөг л одоогийн ханшаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг өнөөдрийн байгаа ханшаар 50 дахин үржүүлбэл энэ хөрөнгө мөнгө. Нэг ёсны хандиваар авах, энэ хандив нэрээр улс төрийн намуудад нөлөөлөх эдийн засаг, хөрөнгө мөнгөний энэ нөлөөллийг дагуулаад янз бүрийн захиалга юунууд орж ирэх, энийг дагасан авлигал хээл хахууль бусад янз бүрийн хууль бус зүйлүүд их байна гэдэг ийм судалгааны юмнууд гарч индекс нөлөөлж байгаа учраас энэ хандивын хязгаарлалтыг нэлээн хатуу хийсэн.

Тийм учраас нэлээн зохицуулалтууд урьд талын хуулиа бодвол орж ирсэн. Хэлэлцүүлгийн явцад гишүүд анхаарна биз дээ гэж бодож байна. Тантай санал нэг байгаа. Энэ ер нь Монголд бол энэ улс төрийн зардлыг багасгах, сонгуулийн зардлыг багасгах асуудал чухал байна. Энийгээ хэрвээ багасгаж чадвал энийг дагаад бид нар бусад нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоог хангах, ёс зүйтэй, эрдэм боловсролтой олон залуучууд, олон хүмүүс орж ирэх ийм хаалга нээлттэй болгох чиглэлтэй.

Тэр агуулгаараа бол энэ удаагийн энэ улс төрийн намуудын үйл ажиллагааг ч гэсэн санхүүгээр нь дамжуулаад энэ багасгах чиглэл рүү олон алтууд орж ирсэн. Яг сонгуулийн үеийн одоо таны хэлж байгаа зардлын асуудал Сонгуулийн хууль руу нэлээн орох юм байна лээ. Энэ өнөөдөр сонгуулийн хууль яг парламентад түвшинд хэлэлцэж байна. Энэ үед улс төрийн намын хууль бас орж ирж байгаа нь ач холбогдолтой гэж харж байгаа юм.

Энэ агуулгаараа авч үзвэл сонгуулийн үед ямар зардал яах юм, Сонгуулийн хууль дээр юунд тусгах ёстой юм, энэ улс төрийн намын хуульдаа юунд тусгах ёстой юм бэ гэдгийг энэ хэлэлцүүлгийн явцад бас нээлттэйгээр хийгээд явах боломж бүрдэж байгаа гэж ингээж харж байгаа. Болсон уу?

Н.Энхболд: Гишүүд асуулт тавьж, хариултаа авлаа. Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад үг хэлэх хүн байна уу? Сүхбаатар гишүүн. Сүхбаатар гишүүний микрофоныг өгье.

Ж.Сүхбаатар: Тэгэхээр Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулга бол хамгийн гол орж ирж байгаа шаардлага нь 2019 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бид маш чухал заалт хийсэн. Улс төрийн намын дотоод ардчиллыг шаардсан, дотоод зохион байгуулалт, үйл ажиллагаа нь ардчилсан байх, хил тод байх энэ шаардлагыг оруулж өгсөн.

Монголын нийгмийн өнөөдрийн үүсээд байгаа олон асуудлуудын хамгийн том хоцрогдол бол энэ намын институц, сонгуулийн институц 2 байгаа байхгүй юу. Энэ сонгууль намын институц бол цаг үеийнхээ шаардлагаас хоцорчихсон учраас Монголын төр муу муухай харагддаг, бас байдаг. Мөн намууд маань бас бэхжиж, хүчирхэгжиж чадахгүй байгаа, сонгууль маань бас цэвэр тунгалаг болохгүй байгаа асуудал чинь байгаа.

Тэгэхээр 11 онд бид нар сонгуулийн хуулийг өөрчлөх ажлыг Нямаа Энхболд гишүүн бид хэд бол энийг хийсэн л дээ. Би Байнгын хороон дарга байж байгаа. Тэгээд үнэхээр тэр маань уг нь Цэцийн хажуугаас ороод ингээд намын хаалттай жагсаалт болоод ингээд сүүлдээ ер нь Их Хурал Цэц 2 хамжиж хийсэн сонгуулийн систем болоод.

Гэхдээ хамгийн гол дутуу юм нь үлдчихсэн юм нь, уг нь би 12 онд сонгогдоод явна гэж бодож байхдаа дараагийн хийгдэж байсан юм нь Улс төрийн намын тухай хууль байсан юм. Энэ намын тухай хууль, Их Хурлын хуралдааны дэг хоёрыг шинэчлэх ажил хийгдээгүйгээс болоод сүүлийн 10 жилийн хугацаанд энэ уг нь зөв эхлээд явж байгаад ингээд 10 жил завсардчихсан ажил, одоо 10 гаруй жил болчхож байгаа юм.

Тэгэхээр энэ асуудал дээр бол хамгийн гол энэ Улс төрийн намын тухай хуулийн зорилго бол сонгуулийн институцтэйгээ уялдсан, Улсын Их Хурлын парламент дахь дотоод баланс нөхцөл байдалтайгаа уялдсан ийм хэлбэрээр явах ёстой.

Тэгээд би тэр Мөнх-Оргил гишүүний хэлээд байгаа намын санхүүжилтийн хууль яах вэ тусдаа байх тухай асуудал яригдсан. Гэхдээ энэ удаа нийлүүлээд ороод ирж байгаа ч гэсэн цаашидаа дараагийн шатандаа шаардлагатай бол бид нар тэрийг нь яах вэ авч үзээд энийгээ тусгаарлаж болох байх. Америкууд бол энэ 75 онд хийсэн шинэчлэлийнхээ энэ улс төрийн санхүүжилтийн хуулийнхаа юмыг одоо хэр нь шинэчилнэ гэж яриад миний мэдэхийн 20 гаруй жил болж байгаа юм. 20 гаруй жил болж байна. Энэ бол маш чухал асуудал.

Гэхдээ улс төрийн намын санхүүжилтийг хэр зөв шийдсэнээс улс төрийн намын шинэчлэлийн эцсийн хувь

заяа тодорхойлогдоно гэдэг ерөнхий тэр философитой би бол санал нийлдэг хүн.

Тэгэхээр одоо ямар ч байсан бид байгаа энэ нэгдсэн кодексе хэлбэр лүү оруулсан хүрээндээ бол энэ удаа бол яг энэ Ерөнхийлөгчийн оруулж ирснийгээ намуудын зөвшилцсөн хүрээнд нь энийгээ Улсын Их Хурал баталж гаргах, 19 оныхоо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэрэгжүүлэх хүрээндээ бол Их Хурал үүн дээрээ анхаарал тавиад гарах явдал маш чухал.

Мөн 2024 оны сонгууль ойртож байна. Удаа дараа хийгдэхгүй байгаа шинэтгэлийн хоцроод байгаа асуудлуудыгаа сонгуулийн хуультай нь хамт энэ түүхэн үүргийг энэ удаагийн парламент гүйцэтгээд, тэгээд энийгээ 1 урагш ахиулахгүй бол 10 жил би алдахад өөрөө харж байна. Миний бодлоор 10 жил бид бол улс төрийн намын институцээ сайжруулах ажлыг хийсэнгүй.

Би ч гэсэн энэ парламент орж ирснийхээ хамгийн гол үүрэг, үр дүн маань энэ бүрэн эрхийнхээ хугацаанд энэ хуулийг өөрөө батлахад нь оролцох юмсан гэж ингээж бодож явсан. Тэгэхээр энэ боломж бол орж ирж байна гэж харж байгаа юм.

Тийм учраас энийгээ хэдүүлээ сайн хэлэлцүүлэхдээ олон талаас, олон намын, бас ардчилсан тэр үзэл бодолтой олон талын хүмүүсийг оролцуулаад бие даасан хүмүүсээ дахиж ярилцаад тэгээд энийгээ Их Хурал маань одоо ингээд хэлэлцээд явах нь бол энэ удаагийн бидний хувьд бол түүхэн үүрэг байх л гэж ингээж харж байгаа юм.

Н.Энхболд: Баярлалаа. Одоо санал хураалт явуулна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн боловсруулж өргөн мэдүүлсэн Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн хууль Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд нь

хэлэлцэх нь зүйтэй гэсэн санал хураалтаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Жоохон далий цохичихлоо.

11 гишүүн санал хураалтад оролцож, 90.9 хувийн саналаар хууль, тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд нь хэлэлцэх нь зүйтэй гэж Байнгын хороо үзлээ.

Санал хураалтын дүнг, ойрд санал хураалтын дүн танилцуулаагүй хүн чинь юм билээ? Сарангэрэл гишүүн ер нь ойрд юу байгаа байх тээ? Тийм, Сарангэрэл гишүүн танилцуулъя.

15.09 цаг

Хоёр дахь асуудалдаа оръё. Түрүүн сонгуулийн тухай 2 төсөл өргөн мэдүүлсэн. Энхболд нарын 4 гишүүн, Цогтгэрэл нарын 2 гишүүн. Тэгээд энэ 2 хуулиа хамтатгаад хэлэлцье гэсэн ийм байр суурь Улсын Их Хурлын чуулганы хуралдааны үеэр гарсан. Цогтгэрэл гишүүн хууль санаачлагчийн хувьд хамтатгаад хэлэлцэнэ гэдгээ дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Тэрийг нь яг протоколын энэ хэсэгт оруулчхаарай.

Би мөн хууль санаачлагчийн нэгийн хувьд энэ 2 хуулиа үзэл баримтлалыг хамт хэлэлцээд явъя гэсэн ийм байр суурьтай байгаа.

Тэгэхээр энийг протоколд тусгаад, Их Хурлын даргад мэдэгдэнэ. Дарга захирамж гаргаж, ажлын хэсэг байгуулах ёстой.

Баярлалаа хуралдаанд оролцсон гишүүддээ. Өнөөдрийн хэлэлцэх асуудал дууслаа.

Байнгын хорооны хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

15.10 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

